

**ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН “НООС” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009.03.20

2008 оны жилийн эцсийн байдлаар

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.

Д.д	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл	
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо	Хөтөлбөрийг Засгийн газрын 2001.02.11-ний өдрийн 26 дугаар тогтоолоор баталсан.	
2	Хөтөлбөр хэрэгжүүлж хугацаа	2001-2010 он	
3	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрийн зорилго нь ноос боловсруулах салбарын эрхэм зорилго, хөгжлийн стратегийн үндсэн чиглэлтэй уялдуулан үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг сайжруулах замаар салбарын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.	
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараахь зорилтуудыг шийдвэрлэнэ: а/ түүхий эд бэлтгэлийн нэгдсэн системийг зах зээлийн нөхцөлд зохицуулан зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчдийн аль алинд нь зохимжтой, түүхий эдийн экспортыг бууруулах, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах; б/ үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах; в/ салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх; г/ бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, зах зээлийг өргөжүүлэх.
		2001-2002 он	Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэлээ хэвийн өсөлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх.
		2003-2004 он	Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг тогтвортой нэмэгдүүлэх.
		2005-2010 он	Ноосон түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, шинээр бий болсон технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээ авч салбарын хөгжлийн стратегийн үндсэн зорилтыг хангах.
5	Хүлээгдэж буй үр дүн	Хөтөлбөрийн нэг ба хоёрдугаар шатны зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна: а/ ноос боловсруулах салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2004 он гэхэд 1999 оныхоос дунджаар 25 хувиар өснө; б/ ноосон бүтээгдэхүүний экспорт 1999 оныхоос 63.4, улсын нийт экспортод тус салбарын бүтээгдэхүүний эзлэх хувь 4.7 хувиар тус тус нэмэгдэнэ; в/ түүхий эдийн боловсруулалтын түвшин сайжирч эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1999 оныхоос 18.8 хувиар өснө; г/ үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 1999 оныхоос 43.1 хувиар өсөж, ажлын байр нэмэгдэн ажилгүйдэл буурна.	

		Хөтөлбөрийн гуравдугаар шатны зорилтыг хэрэгжүүлснээр: а/ улсын хэмжээнд байгаа түүхий эдийн нөөцийн ашиглалт 2010 он гэхэд 2000 оныхоос 29.5 хувиар өснө; б/ ашиглагдаагүй байгаа түүхий эдийг боловсруулах шинэ технологи бий болж, салбарын үйлдвэрүүд хүч чадлаа бүрэн ашиглах нөхцөл бүрдэнэ.						
6	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	10834.7 сая төг					
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	107.3 сая төг /ШУТ-ийн сангаас/					
		тухайн жилд зарцуулсан	-					
7	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	90	70	50	30	Дундаж оноо
		I-II шатны зорилтын хэрэгжилтийн явц	4	4				90%
		III шатны зорилтын хэрэгжилтийн явц	4		2	2		60%
8	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Гүйцэтгэл				хувь	
9	Хөтөлбөрийн хэрэгжилт	Засгийн газрын 2001 оны 26 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл”-ийн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг үндэслэн хяналт-шинжилгээг хийв.						
	1. “Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн системийг зах зээлийн нөхцөлд зохицуулан зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчдийн аль алинд нь зохимжтой, түүхий эдийн экспортыг бууруулах, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах” зорилтын хүрээнд III үе шатанд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явц 2008 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.	<p>I-II шат: ХШҮ 83%</p> <p>- 2002-2004 оны төлөвлөгөөний дагуу Японы буцалтгүй тусламжаар 21 аймгийн 1109 баг, 313 суманд суурилуулсан нийт 2074 цэгт радио станцыг ашиглан түүхий эдийн бэлтгэлийн нөөцийн мэдээг ноосны төрөл, ангилал, чанар, үнийн үзүүлэлтээр аймаг, сум бүрээр сар бүр гаргаж, мэдээллийн сүлжээнд оруулах, мэдээлэл авч нэгтгэн боловсруулах, түгээх талаар холбогдох судалгаа тооцоо хийсэн.</p> <p>- Түүхий эд бэлтгэлийн цэгүүдийг Улаанбаатар хотод Ээрмэл, Улаанбаатар хивс, Нэхээсгүй эдлэл, Монноос, Эсгий, эсгий гутал, Орхон аймагт Эрдэнэт хивс, Дорнод аймагт Дорнод ноос зэрэг ХК-ийг түшиглэн байгуулжээ.</p> <p>- Эрдэнэт хивс, Улаанбаатар хивс, Монноос ХК-ууд орон нутгийн 10 гаруй аж ахуйн нэгжтэй түүхий эд бэлтгэх гэрээ байгуулжээ. Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд нийт бэлтгэсэн түүхий эдийн үнийн 5-10 хувьтай тэнцэх урамшууллыг олгодог болжээ.</p> <p>- Сартуул, Үзэмчин, Барга хонины стандартын төслийг боловсруулж, нарийн, нарийвтар ноост хонины стандартыг дахин хянаж, хонины ноосны бэлтгэлийн стандартуудыг шинэчлэн, холбогдох 18 стандартыг хянан боловсруулж, СХҮТ-ийн зөвлөлийн 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулан мөрдсөн.</p> <p>- Малд тэмдэг тавих зориулалттай Австралийн S-IRO маркийн будаг 2.4 литрийг авчирч судалгаа хийн, цаашид шаардагдах будгийн хэрэгцээг гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг олоход дэмжлэг үзүүлэх асуудлаар Японы элчин сайдын яамтай санал солилцсон.</p> <p>III шат: -Ноосон түүхий эдийн тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад</p>						

		<p>тавих хяналтыг сайжруулах арга аргачлалын стандартыг боловсруулан батлуулсан.</p> <p>-Ноосон түүхий эдийн тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах арга аргачлалын байнгын сургалтыг Нэхмэлийн хүрээлэн дээр зохион байгуулдаг.</p> <p>- Түүхий эд бэлтгэлийн системийг боловсронгуй болгох хүрээнд “Бараа түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 50%</p>
	<p>2. “Үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах” зорилтын хүрээнд III үе шатанд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явц 2008 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.</p>	<p>I-II шат: ХШҮ 90%</p> <p>- Хивсний үйлдвэрүүдээс Австри улсад төлөх өрийн асуудлыг Худалдаа, хөгжлийн банкттай хамтран шийдвэрлэж дуусгав.</p> <p>- 2001-2004 онуудад түүхий эд бэлтгэлийн үеэр арилжааны банкууд ноос боловсруулах салбарын үйлдвэрүүдэд 1.3 тэрбум төгрөгийн 1-2 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг олгожээ.</p> <p>- “Хүн амын орлогын албан татварын тухай хууль”-д өөрчлөлт оруулж, уг хуулийн дагуу дундын суутгалд төлдөг 3 хувийн татвараас угаасан ноос экспортод гаргадаг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг чөлөөлсөн.</p> <p>III шат:</p> <p>- Ямааны ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах цогцолбор” төсөл боловсруулан, хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг гадаад, дотоодын байгууллагуудад танилцуулж байна.</p> <p>- Салбарын тулгамдсан асуудлуудыг Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөлгөөнөөр хэлэлцэн, зөвлөмж гарган, зөвлөлгөөний бичиг баримтад тусгуулан Засгийн газрын 2008 оны 191 дүгээр тогтоол гаргасан.</p> <p>- Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д нэхмэл утсыг бэлтгэх, сэмлэх, самнах, туузлах, сунгах, ээрэх үйл ажиллагаа, ноолуур, ноосон, даавуун нэхмэл үйлдвэрлэх, нэхмэл, сүлжмэл хувцас, эдлэл, хивс, хивсэнцэр үйлдвэрлэлийг хамруулж, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлж байна.</p> <p>- ЖДҮ-ийг дэмжих зээлийн хүрээнд 2008 онд ноос боловсруулах, эсгий, эсгий гутлын 3, сүлжмэлийн 2 жижиг үйлдвэрт зээл олгосон.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 50%</p>
	<p>3. “Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд III үе шатанд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явц 2008 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байна.</p>	<p>I-II шат: ХШҮ 90%</p> <p>- 2001 оны 10 дугаар сарын 2-ны өдөр “Монголын экспортын бараа” үзэсгэлэнг Япон улсын Токио хотноо зохион байгуулж, ноос боловсруулах салбарын 3 үйлдвэр оролцов. МХАҮТ, МННХ-той хамтран “Ноос ноолууран бүтээгдэхүүн -2002” үзэсгэлэн, бизнес уулзалтыг зохион байгуулав. 2002 онд Улаанбаатар хотноо болсон “Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт”-ын үеэр салбарын бүтээгдэхүүн-ий үзэсгэлэнг зохион байгуулсан.</p> <p>- “Хивсний сэв хялгасыг багасгах, монгол ноосон хивсний чанарын үзүүлэлтийг дэлхийн хэмжээнд зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх технологийн шийдэл”-ийг ШУТ-ийн сангийн санхүүжилтээр хийж 2002-2004 онд дуусгасан.</p> <p>- Монголын хивсэн бүтээгдэхүүнийг олон улсын “WOOLMARK” чанарын тэмдэгтэй болгох асуудлыг судлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх асуудлаар мэргэжлийн байгууллагуудтай</p>

		<p>хамтран судалгаа хийжээ.</p> <ul style="list-style-type: none"> - ХХБанкны хувьчлалаар “Хэрлэн хивс” ХК-ийг “Эрдэнэт хивс” ХК-тай хоршин ажиллуулахаар тохиролцоонд хүрч, дараа нь түүний мэдэлд бүрэн шилжүүлэв. - “Нэхээсгүй эдлэл” ХК угаах цех шинээр ашиглалтад оруулж, “Эрдэнэт хивс” ХК угаах цехийг өргөтгөсөн. - Эрдэнэт хивс ХК будгийн цехийн тоног төхөөрөмжийг Итали, ОХУ, БНХАУ-ын тоног төхөөрөмжөөр шинэчлэн утсаар будах технологийг нэвтрүүлсэн. - “Ээрмэл” ХК самнах цехийн тоног төхөөрөмжөө тэмээний ноос самнах зориулалтаар шинэчлэн өөрчилж, жилдээ 100 тонн тэмээний ноос боловсруулах шинэ шугам суурилуулан ашиглалтад оруулжээ. 2003-2004 онд “Ээрмэл” ХК тэмээний ноосон ээрмэл үйлдвэрлэх шугамыг шинээр суурилуулан ашиглалтад оруулснаар тэмээний ноос боловсруулах хүч чадал 50 гаруй хувиар нэмэгдлээ. <p>III шат:</p> <ul style="list-style-type: none"> - Экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зорилтын хүрээнд “Эрдэнэт хивс” ХК бүтээгдэхүүний загвар зохион бүтээх орчин үеийн тооцоолон бодох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, 10 гаруй нэр төрлийн хивс шинээр үйлдвэрлэж байна. Мөн “Говь” ХК тэмээний ноос цайруулах, Санширо ХХКомпани сарлагийн хөөврийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, “УБ хивс”, “Ээрмэл” ХК-ууд монгол хонины ноосноос хялгасыг нь ялгах технологийг нэвтрүүлж, 10 орчим нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. Шинэ бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Бүтээгдэхүүний чанар, техник, технологийг сайжруулах” СМЭТ олон улсын үзэсгэлэн яармагт тавьж сурталчлав. Ноосон дорож ХБНГУ-ын Ахен институтын галд тэсвэртэй сертификатад авсан. - “Монгол нэхмэл” ХК гүйцэтгэн боловсруулалтын тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан. Тус компаний үйлдвэрлэсэн сарлагийн хөөвөр, ноосон драпаар “Амно” ХХК эрэгтэй, эмэгтэй пальто үйлдвэрлэж байна. - “Эрдэнэт хивс” ХК шинээр 600 тн ээрмэл үйлдвэрлэх технологийн шугам, ноосон хөнжил хийдэг шугам суурилуулан жилдээ 15.0 мян ширхэг хөнжил, 100.0 мян хос эсгий шаахай, 1.2 мян м2 гар тавтинг хивс, 25.0 мян.м гэрийн эсгий, 4.0 мян хос эсгий гутал, бэлэг дурсгалын утсан болон эсгий урлал үйлдвэрлэжээ. Мөн ноосны чиглэлийн хонины үүлдэр угсааг сайжруулах ШУ-ны төсөл хэрэгжүүлэн, 900 хүнийг ажлын байраар ханган ажилласан. Цаашид жил бүр 5000 тн бохир ноос хүлээн авч 1500 хүнийг ажлын байраар ханган оюуны өндөр багтаамжтай экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр ажиллаж байна. - Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн дээр төсөл хэрэгжүүлэн эсгий, эсгий гутал үйлдвэрлэх жижиг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг зохион бүтээн үйлдвэрлэлд нэвтрүүлжээ. Одоогоор 18 суманд жижиг үйлдвэр байгуулан ажиллаж байна. <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p>
	<p>4. “Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, зах зээлийг өргөжүүлэх” зорилтын хүрээнд</p>	<p>I-II шат: ХШҮ 90%</p> <ul style="list-style-type: none"> - Ботго, торомны ноос, тэмээний эм ноос, зогдор, сарлагийн хөөвөр, ямааны ноос, адууны дэл, сүүл, үхэр, адууны хөөвөр зэрэг түүхий эдийн бэлтгэлийн стандартуудыг шинэчлэн СХҮТ-ийн зөвлөлийн 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн

<p>III үе шатанд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явц 2008 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байна.</p>	<p>хурлаар хэлэлцүүлэн батлан мөрдөж байна. Анхан шатны боловсруулалт хийсэн хонины ноосны стандартыг дахин хянаж СХҮТ-ийн Зөвлөлийн 2002 оны 5 сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Хонины ноос, ноолуур ялган авах шинэ технологи боловсруулж Ээрмэл, Улаанбаатар хивс ХК-д, 2002-2003 онд тэмээний ноос цайруулах технологийг Говь, Мон-Форте, Монгол Амикаль компаниудад, Тэмээний эр ноосоор хивс үйлдвэрлэх технологийг “Улаанбаатар хивс” ХК дээр нэвтрүүлэв. Хялгасыг нь ялгасан ноосоор ээрмэл үйлдвэрлэж, хивс үйлдвэрлэснээр хивсний сэв хялгас 20 гаруй хувиар буурах боломж бүрдэв. 2002 онд “Сарлагийн хөөврийг гүн боловсруулах арга технологи” төслийг ШУТС-аас санхүүжүүлэн хэрэгжүүлэв. 2002-2004 онд “Сарлагийн хөөврөөр цэмбэ үйлдвэрлэх технологийг “Моннэхмэл”, “Санширо” компаниуд туршиж, үр дүнд хүрчээ. - 2002-2004 онд Хонины ноосны шинж чанарын улсын нэгдсэн ангилал тогтоох тухай төслийн санал бэлтгэж, 2002 онд Улаанбаатар хотноо болсон Монголд хандивлагчдын 9 дүгээр чуулга уулзалтад танилцуулсан. - “Ноосны чиглэлийн ямааны ноосонд гүн боловсруулалт хийж ямааны уртлаг ширхэгтэй ноосоор тэмээний ноос, сарлагийн хөөврийг сайжруулах холионы оновчтой горимыг тогтоон, шинэ нэр төрлийн ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи” төслийг ШУТС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэн, 2005 онд Нэхмэлийн хүрээлэн жижиг үйлдвэрлэлд нэвтрүүлж эхэлсэн. - 2001-2005 онд ОХУ-ын урсгал өрөнд угаасан ноос, хивс нийлүүлэх боломжийн талаар тооцоо гаргаж, холбогдох яам, газруудад хүргүүлсэн. - Ноосон бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн мэдээллийн „WEB” хуудсыг Нэхмэлийн хүрээлэн дээр нээн ажиллуулжээ. - Хивсэн бүтээгдэхүүнийг олон улсын чанарын тэмдэгтэй болгох асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажилласан. - Горный-Алтайск мужаас Баян-Өлгий аймгийн ноос угаах үйлдвэрт хөрөнгө оруулалт хийн, баруун аймгийн ноосыг угааж экспортлох болсон. <p>III шат:</p> <ul style="list-style-type: none"> - Хонины ноосны шинж чанарын улсын нэгдсэн ангилал тогтоох чиглэлээр Нэхмэлийн хүрээлэн дээр дэлгэрэнгүй судалгаа явуулж үндэсний стандарт боловсруулав. - “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулан батлуулан, мөрдөн хэрэгжүүлж байна. - “Нэхээсгүй эдлэл” ХХК-нд Каркастай эсгий үйлдвэрлэх технологийг нэврүүлсэн. - Түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор ШУТ-ийн сангийн санхүүжилтээр “Ширүүн, ширүүвтэр ноосны боловсруулалтын түвшинг сайжруулж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх”, “Тэмээний эр ноосыг бүрэн боловсруулж үйлдвэрлэл техникийн зориулалттай шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулж нэвтрүүлэх” төслүүдийг хэрэгжүүлж байна. - 2008 онд “Эрдэнэт хивс” ХК 4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж тоног төхөөрөмжөө шинэчилсэн бөгөөд “Хүннү”
---	--

		<p>брэндийн хивсээрээ “Woolmark” чанарын тэмдэг авсан.</p> <p>- Салбарын үйлдвэр, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Монголд үйлдвэрлэв”, “Ноос ноолуур” үзэсгэлэн, худалдааг сүүлийн 3 жил дараалан зохион байгууллаа.</p> <p>- ОХУ-тай худалдааг либериальчлах хүрээнд тэмээний ноосон цамц, хөнжлийг татвараас чөлөөлөх талаар санал солилцож, ОХУ-аас дэмжихээ илэрхийлжээ. Уг импортын татварын хөнгөлөлтөд хивсийг хамруулах саналыг ОХУ-ын талд тавиад байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p>
<p>Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/</p>		<p>Хөтөлбөрийн 4 зорилтын хүрээнд эхний 2 шатны 2001-2004 онуудад хэрэгжих арга хэмжээний биелэлт 90 хувьтай дүгнэгджээ.</p> <p>Хөтөлбөрийн III үе шатанд /2005-2010 онд/ тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явц нь 2008 оны жилийн эцсийн байдлаар 60 хувьтай байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад арьс, ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн болон бизнесийн таатай орчин бүрдсээр байна. “Ямааны ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах цогцолбор” төслийг монгол, англи хэлнээ боловсруулсан. Салбарын тулгамдсан асуудлуудыг зөвлөлгөөнөөр хэлэлцэн, гарсан зөвлөмжийг бичиг баримтад тусгуулан Засгийн газрын 2008 оны 191 дүгээр тогтоол гаргасан. Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д нэхмэл утсыг бэлтгэх, сэмлэх, самнах, туузлах, сунгах, ээрэх үйл ажиллагаа, ноолуур, ноосон, даавуун нэхмэл үйлдвэрлэх, нэхмэл, сүлжмэл хувцас, эдлэл, хивс, хивсэнцэр үйлдвэрлэлийг хамруулж, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлж байна.</p> <p>Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч, тодорхой үр дүнд хүрсэн. ШУТ-ийн сангийн санхүүжилтээр ноосны гүн боловсруулалт хийх болон шинэ бүтээгдэхүүн хийх технологи боловсруулах төслүүдийг хэрэгжүүлж, Ээрмэл, Говь, Мон-Форте, Монгол Амикаль, “Улаанбаатар хивс” ХК-д, “Моннэхмэл”, “Санширо” компаниудад нэвтрүүлэн 10 орчим нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлжээ. Шинэ бүтээгдэхүүнээ олон улсын болон дотоодын үзэсгэлэн яармагуудад тавьж сурталчлав. Ноосон дорож ХБНГУ-ын Ахен институтын галд тэсвэртэй сертификатад авсан.</p> <p>Ээрмэл ХК, Монгол ноолуур, тэмээний ноос ХХК-ууд самнах цехийн тоног төхөөрөмжөө шинэчлэн, ээрмэл үйлдвэрлэх шугамыг шинээр суурилуулан, хүч чадал 50 хүртэл хувиар нэмэгдүүлжээ. Нэхээсгүй эдлэл ХК, Эрдэнэт хивс ХК-иуд угаах цехийг өргөтгөн, будгийн цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэн утсаар будах технологийг нэвтрүүлсэн.</p> <p>“Эрдэнэт хивс” ХК бүтээгдэхүүний загвар зохион бүтээх орчин үеийн тооцоолон бодох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, 10 гаруй нэр төрлийн хивс шинээр үйлдвэрлэж байна. “Хүннү” брэндийн хивсээрээ “Woolmark” авсан. Өөрийн хөрөнгө оруулалтаар 600 тн ээрмэл үйлдвэрлэх технологийн шугам, ноосон хөнжил хийдэг шугам суурилуулан жилдээ 15.0 мян ширхэг хөнжил</p>

болон 100.0 мян хос эсгий шаахай, 1.2 мян м2 гар тавтинг хивс, 25.0 мян м гэрийн эсгий, 4.0 мян хос эсгий гутал, бэлэг дурсгалын утсан болон эсгий урлал хийж жилдээ 8.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, үүнээс 100.0 мян м2 хивс, 5.0 мян ширхэг хөнжил, 90 тн ээрмэл, 2.0 мян хос эсгий улавч экспортложээ.

Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах зорилтын хүрээнд ноосны чанарыг сайжруулж, бүдүүвтэр, нарийн нарийвтар ноост хонины тоо толгойг нэмэгдүүлэх, уг асуудлаар ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төслүүдтэй хамтран ажиллах нь зүйтэй байна. Зах зээлийн хэрэгцээг судлан, техникийн эсгий, барилгын дулаалгын материал үйлдвэрлэх технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломж байна.

Түүхий эд бэлтгэлийн цэгүүдийг салбарын томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд түшиглэн байгуулах, орон нутгийн аж ахуйн нэгжтэй түүхий эд бэлтгэх гэрээ байгуулах, түүхий эд бэлтгэлийн үеэр арилжааны банкууд ноос боловсруулах салбарын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээлийг олгох арга хэмжээнүүдийг хөтөлбөрийн эхний шатуудад амжилттай хэрэгжүүлсэн боловч III шатанд уг ажил үндсэндээ зогссчээ.

Түүхий эд, бэлтгэлийн чанарыг сайжруулах холбогдох стандартыг дахин хянаж, шинэчлэн боловсруулж, СХҮТ-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулан мөрдсөн. Ноосон түүхий эдийн тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах арга аргачлалын стандартыг боловсруулан батлуулсан.

Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх, түүхий эдийн экспортыг бууруулах талаар дорвитой ажил хийгдээгүй байна.

Салбарын үйлдвэрлэгчдэд санхүү, зээл, татвар, даатгалаар дэмжих эрх зүйн орчин бий болсон ч эдгээр үйлчилгээний хүртээмж бага, хүрээ нь хязгаарлагдмал тул зээл олгох механизмыг хөнгөвчлөх, зээлийн баталгаа, даатгалын тогтолцоо бүрдүүлэлтийг эрчимжүүлэх нь чухал байна.

Ноосны үйлдвэрүүдийг бодлогоор төвлөрүүлж, ноосны бэлтгэл - нөөц, тээвэрлэлт ба эцсийн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт - нийлүүлэлттэй уялдуулан оновчтой хэлбэрээр бүсчилэн хөгжүүлэх, салбарт шинжлэх ухаан-технологийн инновацийг эрчимтэй хөгжүүлэх, урт хугацааны хөрөнгө оруулалтын зээл тусламжаар хангах, хөрөнгө оруулалт, экспортыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээг цогцолбороор шийдвэрлэх нь оновчтой. Монголын ноосны салбарын өнөөгийн байдал, дэлхийн ба дотоодын зах зээлийн эрэлт-нийлүүлэлт, үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт, тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа явуулах, салбарын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үр дүнгийн статистик үзүүлэлт:

2008 онд ноосны салбарын гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн боловч экспортын хэмжээ буурсан байна.

Үйлдвэрлэлтийн хувьд:

- 2005 оны зэрэгцүүлэх үнээр нэхмэлийн үйлдвэрлэлийн хэмжээ 2005 онд 65913.9, 2006 онд 112261.5, 2007 онд 127101.2, 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 135083.8 сая

	<p>төгрөгт хүрч 6.7 хувиар өссөн. Нэхмэлийн үйлдвэрлэлт нь боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтэд 2006 онд 27.8 хувь, 2007 онд 22.8 хувь, 2008 онд 19.7 хувийг эзэлж 3 хувиар буурчээ.</p> <p>- Угаасан ноосны үйлдвэрлэлт 2006 онд 1107.8 тонн болж 24.8 хувь, 2007 онд 1670.8 тонн, 2008 онд 1778.1 тоннд хүрч, 6.4 хувиар өссөн байна. Тэмээний ноосон хөнжлийн үйлдвэрлэлтийн хэмжээ 2006 онд 34.4 мян.метр болж 2.0 хувиар, 2007 онд 37.7 мян. метр болж, 9.6 хувиар өссөн бол 2008 онд 35.0 мянган метр болж, 7.2 хувиар буурсан. 2006 онд хивсний үйлдвэрлэлт 606.3 мян. м2 болж 3.3 хувиар, 2007 онд 658.1 мян.м2 квадрат болж, 8.5 хувиар, 2008 онд 856.5 мян.м2 квадрат болж, 30 хувиар өссөн. Эсгий гутлын үйлдвэрлэлт 2006 онд 7.8 мянган хос болж 24 хувиар буурсан, 2007 онд 9.3 мян.хост хүрч, 20.3 хувиар өссөн бол 2008 онд 6.3 мян.хост хүрч, 22 хувиар буурчээ. Эсгий үйлдвэрлэлт 2006 онд 68.8 мян.м болж 0.4 хувиар буурсан, 2007 онд 87.8 мян.м болж, 27.6 хувиар өссөн, 2008 онд 86.5 мян.м болж, 1.5 хувиар буурсан. Ээрсэн утасны үйлдвэрлэлт 2006 онд 38.5 тоннд хүрч 46 хувиар, 2007 онд 32.8 тонн болж 14.8 хувиар, 2008 онд 28.1 тонн болж 14.3 хувиар буурчээ.</p> <p>- Сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэлт 2006 онд 617.2 мян ширхэгт хүрч 7 хувиар буурсан, 2007 онд 667.1 мян ширхэг болж 8 хувиар өссөн бол 2008 онд 514.3 мян ширхэг болж 22 хувиар буурсан.</p> <p><u>Экспортын хувьд:</u></p> <p>- Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 2006 онд 246.7 сая ам. долл, 2007 онд 262.6 сая ам.долл, 2008 онд 225.4 сая ам долл болж 14.2 хувиар буурчээ.</p> <p>- Хонины самнаагүй ноос 2006 онд 6377.9 тн, 2007 онд 9139 тн, 2008 УГ-ээр 9246.8 тн-ыг экспортложээ.</p> <p>- Ноосон ээрмэлийн экспорт биет хэмжээгээр 2007 онд 37.8 тн, 2008 онд 10.7 тн болж 3 дахин буурсан бол үнийн дүнгээрээ 2007 онд 974.5 мян ам долл, 2008 онд 1226.5 мян ам.долл болж 25 хувиар өслөө. Ноосон хувцас, эдлэлийн экспорт 2007 онд 39568.2 мян ам долл, 2008 онд 20517.6 мян ам.долл болж бараг 2 дахин буурчээ.</p> <p><u>Ажиллах хүчний хувьд:</u></p> <p>- Салбарын хөдөлмөрийн бүтээмж 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2007 онд 26131.1 мян төг, 2008 онд 28921.2 мян төг болж, 10.7 хувиар өсжээ.</p> <p>- Уг салбарт ажиллагсдын тоо 2006 онд 4799 , 2007 онд 5310 болж, 10.6 хувиар өссөн бол 2008 онд 5018 болж 5.5 хувиар буурчээ.</p> <p><u>Зөвлөмж:</u></p> <p>- Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт, тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа явуулж, салбарын тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, түүний дагуу хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах,</p> <p>- Түүхий эдийн бэлтгэл, чанарын хамгаалалт, тээвэрлэлт, нийлүүлэлт, үнийн нэгдсэн системийг бий болгох, түүхий эдийн экспортод хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх,</p>
--	---

		<ul style="list-style-type: none"> - Ноосны чанарыг сайжруулах, бүдүүвтэр, нарийн нарийвтар ноост хонины тоо толгойг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төслүүдтэй хамтран ажиллах, - Ноосон бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах, гадаадын зах зээлд гаргахад худалдааны хөнгөлөлтийн системийг ашиглах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, - Ноолуур, ноос боловсруулах цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, энэ ажлын хүрээнд салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг шийдвэрлэх нь оновчтой, - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх III үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг оны хуваарьтай үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хөрөнгийн эх үүсвэрийн хамт боловсруулан батлуулах, - Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хүрсэн үр дүн, шаардагдах санхүүжилтийн шийдвэрлэлт, түүний зарцуулалтын талаархи мэдээллийг тусгах.
12	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	<ul style="list-style-type: none"> - Салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд санхүү, зээл, татвар, даатгалаар дэмжих эрх зүйн орчин бий болсон ч эдгээр үйлчилгээний хүртээмж бага, зээл олгох хүрээ нь хязгаарлагдмал байна. - Хөтөлбөрийн үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэр батлагдахгүй байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	Оролцогч талууд хамтран ажилласан. Гэвч салбарын үйлдвэрүүд төсөл хамтран хэрэгжүүлэх, стратегийн чиглэлээр дагнах, нэгдэх замаар хүсэн хүлээсэн үр дүндээ хүрэх, үндэсний ноосны бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчид стратегийн түншлэлийн холбоо тогтоох чиглэлээр боломж, давуу талаа ашиглах нь чухал.
14	Хөтөлбөрийн талаархи яамны санал	<ul style="list-style-type: none"> - “Ноос” дэд хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх III үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг оны хуваарьтай үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг тодорхой тусган боловсруулан батлуулах, уг санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

Танилцсан:

МХШҮГ-ын дарга

Л.Баяртулга

Хяналт-шинжилгээний үнэлгээ, зөвлөмж өгсөн:

МХШҮГ-ийн ахлах мэргэжилтэн

Д. Алтанлит